



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/07

Ховд

Хичээл сургалтын үйл ажиллагааг түр  
хойшлуулах, хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 358 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2020 оны А/05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчний халдвар нийт амбулаторийн үзлэгийн 15.1 хувийг эзэлж, дэгдэлт хэлбэрээр бүртгэгдэх болсон тул сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 01 дүгээр сарын 20 хүртэл түр хааж, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн амралтыг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл 7 хоногоор сунгасугай.

2.Дээрх хугацаанд олон нийтийг хамарсан уралдаан, тэмцээн бусад нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байхыг аймгийн албан байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

3.Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулах, хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчлэх, эмчийн үзлэг, хяналтыг гэрийн үйлчилгээнд шилжүүлэх, орны тоог нэмэгдүүлэх, эм хэрэгсэл, хүний нөөцийг бэлтгэх зэрэг удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийг бүх шатны Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

4.Томуу томуу төст өвчлөлийн байдал түүнээс урьдчилан сэргийлэх талаар байгууллага, иргэд, олон нийтэд сурталчлан зөвлөгөө өгөх, өвчлөлийн байдалд хяналт тавьж, холбогдох удирдлагуудыг мэдээ, мэдээллээр тасралтгүй хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/, Эрүүл мэндийн газрын

Zax A/07 Ch

02.00029

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /Б.Оюунтунгалаг/, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт хариуцуулсугай.

5.Жирэмсэн болон 5 хүртэлх насны хүүхдүүд нь ханиад томуугаар өвчилж, эмчлүүлэх, хүүхдээ асрах зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчдад 3-5 хоногийн цалинтай чөлөө олгохыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж холбогдох арга хэмжээг шуурхай авч, өвчлөлийг богино хугацаанд цомхотгох зохион байгуулалтын нэмэлт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Б.Алтанбадралт, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн, Боловсрол, соёл урлагийн газрын дарга М.Пүрэвхүү, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Эрдэнэчулуун нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Ч.УРАНЧИМЭГ